



SOMMET DE L'ÉLEVAGE



Европын мал аж ахуйн тэргүүлэх үзэсгэлэн

2023 оны 10 дугаар сарын 3-6-ний өдрүүдэд Франц улс | Клэрмон-Ферран хот

105 000 зочид 1 550 оролцогчид 2 000 толгой мал

ФРАНЦЫН ШИЛМЭЛ МАЛ

Франц Улсын Клэрмон-Ферран хот нь Европ тивийн зүрхэнд орших “Төвийн өндөрлөг”-т байрладаг бөгөөд махны үхэр үржүүлгийн хамгийн том бүс нутаг юм. Клэрмон-Ферран МАЛ АЖ АХУЙН ҮЗЭСГЭЛЭН, ХУДАЛДАА нь мал аж ахуй (үхэр, хонь, адуу гэх мэт)-гаар төрөлжсөн олон улсын томоохон үзэсгэлэн, худалдааны нэг юм.

Үзэсгэлэнд 2,000 толгой шилмэл мал оролцоно. Үүнд:



1300 үхэр

Сүүний болон махны чиглэлийн 22 үүлдэр



400 хонь

26 үүлдэр



300 адуу

16 үүлдэр

МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ИЖ БҮРЭН САНАЛ

Малын сонгон үржүүлэг, тэжээллэг, эрүүл мэнд, эрүүл ахуй, саалийн болон сүү боловсруулах төхөөрөмж, мал аж ахуйн тоног төхөөрөмж, үйлчилгээ, фермийн барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүч, хөдөө аж ахуйн машин механизм гэх мэт...



200,000 м² үзэсгэлэнгийн талбай



105,000 зочид, үзэгчид
(80 орны 5,000 гадаад төлөөлөгч)



1,550 оролцогч
(35 орны 310 гадаад оролцогч)



ЕВРОПЫН МАХНЫ
ҮХРИЙН АЖ
АХУЙН ТЭРГҮҮЛЭГЧ
ФОРУМ

“Уулархаг нутагт мал
аж ахуй эрхлэх нь”
зөвлөгөөн

ФЕРМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ ХӨТӨЧТЭЙ АЯЛАЛ

Франц Улсын нутгийн үхэр, хонь, ямааг үзэхийн зэрэгцээ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй (мал нядалгааны газар, үхрийн экспортын төв, мал бордооны талбай, бяслагийн үйлдвэр, био-хийний үйлдвэр...) -тай танилцах боломжтой.

Орчуулагч болон мэргэжилтэн хөтөчтэй 25 аж ахуйтай танилцах аялал Энэ аяллаар явахад үзэсгэлэнгийн газраас өдөр бүр автобусаар үйлчилнэ.



Доорх холбоосоор орж бүртгэл болон хөтөлбөртэй танилцана уу.
www.sommet-elevage.fr

ГАДААДЫН ЗОЧДЫГ ДЭЭД ТҮВШИНД ХҮЛЭЭН АВДАГ!

Орох тасалбар үнэгүй: угтах үйлчилгээ, орчуулагч, хөтөч, залбирлын өрөө, оролцогч байгууллагуудтай бизнесийн уулзалт хийх зэрэг үйлчилгээ багтсан.

Манай **Олон улсын бизнесийн клуб** нь таныг үзэсгэлэнд оролцож буй байгууллагуудтай үр дүнтэй холбоо тогтооход тусалж ажиллах болно.

Клубээр зочлохоо мартуузай! Тантай үулзах хүсэлтэй зочид болон оролцогчид бидний “холбоо тогтоох самбар”-аар дамжуулан танд зурвас үлдээсн байж магадгүй!



2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон улсын мал аж ахуйн үдэшлэг

Гадаадын зочин төлөөлөгчдөд Франц Улсын үхэр, хонь, ямаа, адууны үүлдрүүдийг танилцуулах. 10 сарын 4-ны Лхагва гаригт 19:00 цагт үзэсгэлэнгийн байранд.

Лимузин үүлдрийн улсын шалгаруулалт (400 үхэр)

Бор үүлдрийн улсын шалгаруулалт (150 үхэр)

Монбельярд үүлдрийн улсын шалгаруулалт (140 үхэр)

Үхэр, хонь, адууны үүлдрүүдийн шалгаруулалт: Аубрак, Шароле, Салерс, Блонд Д'Акитайн, Гольштейн, Хар тарлан, Шведийн бор, Норманд, Симментал (Шар тарлан), Иль Де Франц, Тексель, БиЭмСи, Першерон, Арденны...

Мал аж ахуй эрхлэхэд тулгамдаж байгаа асуудлаарх 100 гаруй хурал зөвлөгөөн болно.



МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЕВРОПЫН УУЛЗАЛТ

ОЛОН УЛСЫН ЗОЧИД

Үнэгүй нэвтрэх эрхийн мандат захиалах болон фермийн аялалд доорх цахим хаягаар бүртгүүлнэ үү:
www.sommet-elevage.fr

Айлчлалын явцдаа манай нутгийн аялал жуулчлалын үзэсгэлэнт газруудаар зочилно үү.



танд хэрэгтэй мэдээлэл

ТЭЭВЭР

Нисэх буудал болон төмөр замын буудлаас хотын төв, үзэсгэлэнгийн парк хооронд үнэгүй тээврийн үйлчилгээтэй (Гарц №2)

Дэлгэрэнгүй мэдээлэл авах холбоос: www.sommet-elevage.fr

БАЙР

● АГРИЛИЗ – Хөдөө аж ахуйн аялал жуулчлалын агентлаг (байр, дотоодын болон олон улсын тээвэр)
Утас: +33 (0) 1 82 83 33 56; Цахим шуудан: sommet@agrily.fr

● Клермон-Ферран жуулчлалын төв

Утас: +33 (0) 4 73 98 65 00

Цахим шуудан: congres@clermontauvergnetourisme.com

ҮНЭГҮЙ НЭВТРЭХ

Олон улсын зочид болон өндөр зэрэглэлийн зочид, төлөөлөгч нар Олон улсын бизнес клуб-т үнэгүй нэвтрэнэ.

Доорх холбоосоор орж урьдчилсан бүртгүүлнэ үү.

www.sommet-elevage.fr

Холбоо барих



УБ хот ЧД, 2-р хороо,
Бакула Ренбүчигийн гудамж,
8-ын 4-р байр
«Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн төв»
- С. Энхбат, Утас: +976 9903 7377
Цахим шуудан: enkhbat@mosard.mn
Веб хуудас: www.mosard.mn



Франц улс,
Клермон-Ферран хот,
СОММИТ ДЭ Л'ЭЛЭВАЖ
Олон улсын менежер
н. Боноет ДЭЛАЛОЯ
Утас: +33 (0)4 73 28 95 10
Цахим шуудан: bdelaloy@sommet-elevage.fr

